

**“ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА” ХХК**

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН  
БУЛГАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ЭРДЭС БОРДОО  
ИМПОРТЛОХ, ХАДГАЛАХ, АШИГЛАХ, БОРЛУУЛАХ”  
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

РД:2034565

Улаанбаатар хот 2022 он

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ  
“ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АГУУЛГА

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1 Төслийн нэр .....	3
1.2 Төслийн зорилго .....	3
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл .....	3
1.4 Төслийн байршил .....	4
1.5 Тариалангийн талбай .....	4
1.6 Хүчин чадал, ажиллах горим .....	6
1.6.1 Төслийн талбайн агуулахын хүчин чадал .....	6
1.6.2 Төслийн талбайн хүчин чадал .....	6
1.6.3 Ажлын горим.....	6
1.7.1 Бордоо хэрэглэх технологи.....	7
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН,ЭДИЙН-ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	9
2.1 Гадаргын нөхцөл .....	9
2.2 Хөрсөн бүхэвч .....	9
2.3 Уур амьсгал.....	9
2.4 Агаарын чанар.....	10
2.5 Хөвсгөл аймийн агаарын чанарын үзүүлэлт.....	10
2.6 Гадаргын ус.....	12
2.7 Газрын доорхи ус.....	12
2.8 Ан амьтан .....	13
2.9 Ургамалан бүрхэвч.....	13
2.10 Усан хангамж.....	14
2.11 Эдийн засаг .....	14
2.12 Лаборатори .....	14
2.13 Авто зам.....	14
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ ӨӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	16
3.1 Газар болон хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	16
3.2 Агаар, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	16
3.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	16
3.4 Хөрс, ургамал, амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл.....	16
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙНТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	17
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	19
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	22
БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	24
БҮЛЭГ 9. ХОГ, ХЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	26
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	27
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	29

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ  
“ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ..... 30

ЗУРАГ

Зураг №. 1 Төөсөл хэрэгжих т үйлдвэрлэлийн талбайн байршил .....	4
Зураг №. 2 Эрдэс бордооны агуулах.....	5
Зураг №. 3 Төслийн бордоо .....	6
Зураг №. 4 Уур амьсгалын нөөцийн олон жилийн дундаж үзүүлэлт .....	10
Зураг №. 5 Газрын доорхи усын нөхөн сэргээгдэх нөөц.....	12

ХҮСНЭГТ

Хүснэгт №. 1 Төслийн мэдээлэл.....	3
Хүснэгт №. 2 Тариалнгийн үйлдвэрлэлийн ажиллах хүчний ажилын горим .....	7

## БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Төслийн нэр

“Эрдэс бордоо импортлох, түр хадгалах, хэрэглэх, борлуулах” төсөл

### 1.2 Төслийн зорилго

“Эрдэс бордоо импортлох, түр хадгалах, хэрэглэх, борлуулах” төслийг хэрэгжүүлэх гол зорилго нь тариалангийн үйлдвэрлэлийн өгөөжийг нэмэгдүүлэх явдал бөгөөд үүнд таримлыг зөв, зохистой тэжээлээр хангах асуудлыг шийдвэрлэх нь төслийн гол зорилго болно. Төсөл гол зорилгоо хангах үйл ажиллагаагаа улаан буудайн шим тэжээлийн хэрэгцээг хангах асуудлаас эхлэх бөгөөд үүний тулд чанартай эрдэс бордооны нийлүүлэлтийг шийдвэрлэнэ. Төслийн хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

Эхний ээлжинд өөрийн компанийн улаан буудайн үйлдвэрлэлийг импортын эрдэс бордоогоор хангана. Импортоор оруулж ирсэн эрдэс бордоог жил өнжөөн хадгалаагүй ба өөрийн хэрэгцээнээс гарсан илүүдэл бордоог орон нутагтаа борлуулна. Цаашдаа эрдэс бордооны импортыг жилүүдээр ахиулан бүс нутгийн хэмжээнд улаан буудай тариалагчдын хэрэгцээг хангах хүртэл импортлох бордооны хэмжээг өсгөнө. Эрчимжсэн технологиор тариалан эрхэлж байгаа ААНБ-уудын судалгаа хийж бордоо нийлүүлэх гэрээ хэлцэл хийж, илүүдэл бүтээгдэхүүнийг борлуулна. Шаардлагатай тохиолдолд бордоог Монгол орны хөрс, цаг уурын нөхцөлд туршиж, үр дүнд үндэслэсэн импортын гэрээ байгуулна.

### 1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


Хүснэгт №. 1 Төслийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Хөвсгөл Алтандуулга”
Төсөл	“Эрдэс бордоо импортлох, түр хадгалах, хэрэглэх, борлуулах” төсөл
Тусгай зөвшөөрлийн дугаар	-
Улсын бүртгэлийн дугаар	9011688108
Регистрийн дугаар	2034948
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар, 8-р хороо, оюутны гудамж, 24-р байр, 33тоот.
Утас	310249

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ  
“ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

#### 1.4 Төслийн байршил

“Хөвсгөл алтандуулга” ХК-ий газар тариалангийн үйлдвэрлэл нь Хөвсгөл аймгийн Тариалан сумын нутагт явагдана. Компанийн үйлдвэрлэлийн талбай Тариалан сумын 3 дугаар багийн нутагт 6701001230 нэгж талбарын дугаартай 6175 га бүхий 42 талбай, 7 дугаар багын нутагт 6701001215 нэгж талбарын дугаар бүхий 870 га талбайн үр тарианы усалгаагүй тариалан эрхлэх зорилгоор эзэмших байна.



Зураг №. 1 Төөсөл хэрэгжих т үйлдвэрлэлийн талбайн байршил


#### 1.5 Тариалангийн талбай

“Хөвсгөл Алтандуулга” ХК-ий газар тариалангийн үйлдвэрлэл нь Хөвсгөл аймгийн Тариалан сумын нутагт явагдана. Компанийн үйлдвэрлэлийн талбай Тариалан сумын 3 дугаар багийн нутагт 6701001230 нэгж талбарын дугаартай 6175 га бүхий 42 талбай, 7 дугаар багын нутагт 6701001215 нэгж талбарын дугаар бүхий 870 га талбайн үр тарианы усалгаагүй тариалан эрхлэх зорилгоор эзэмших байна.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ  
“ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Эрдэс бордооны агуулах:**

Манай компани нь экспортоор оруулж ирж буй бордоогоо чанаарын шаардлага хангасан агуулахад хадгалах зорилгоор Булган аймгийн Булган сумын нутагт орших ХААДСангийн эрдэс бордооны агуулахыг түүрээсээлэн ашигладаг. Тус агуулахын байршлыг доорх зурагт харуулсан байна.



Зураг №. 2 Эрдэс бордооны агуулах

## 1.6 Хүчин чадал, ажиллах горим

### 1.6.1 Төслийн талбайн агуулахын хүчин чадал



Зураг №. 3 Төслийн бордоо

А.Азотын:	Б. Нийлмэл бордоо:
1. Карбамид марка б, высший сорт	1. Азофоска NPK (MOP) 20:10:10
2. Карбамид марка гранул	2. Азофоска NPK (MOP) 16:16:16
3. Селитра аммиачная марка б, высший сорт	3. Азофоска NPK (MOP) 25:9:9
	4. Азофоска NPK (MOP) 15:15:15
	5. Азофоска NPK (MOP) 19:9:19
	6. Азофоска NPK (MOP) 18-6-18+Mg+S
	7. Азофоска NPK (MOP) 23:10:5:2+Mg
	8. Азофоска NPK (MOP) 23-22

Тус агуулах нь азотын 3, нийлмэл 8 нэр төрлийн бордоо, гербицид-7 төрөл, интексид-3, фунгицид-5 буюу нийт 26 нэр төрлийн ургамал хамгааллын бодисуудыг хадгалахаар байна.

### 1.6.2 Төслийн талбайн хүчин чадал

Тус төсөл нь үндсэн 16 ажилтантай, жилд 210-225 хоног ажиллана. Төсөл нь газар тариалангийн үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэр гэсэн 2 үндсэн үйлдвэрлэлтэй. Газар тариалангийн үйлдвэрлэл нь жилд 5000-6000 тн үр тариа үйлдвэрлэх хүчин чадалтай. Боловсруулах үйлдвэр нь хоногт 100 тн будаа тээрэмдэж, 10 тн тэжээл гаргах хүчин чадалтай байна. Голлох таримал нь улаан буудай бөгөөд зөөлөн, хатуу төрөлд хамаарах 8-12 төрлийн сортоос гадна овъёос тосны ургамал, халтар арвай тариалдаг тариалж, үрийн нөөцөө дотоодоосоо 100% хангадаг.

### 1.6.3 Ажлын горим

Газар тариалан нь улирлын үйл ажиллагаатай үйлдвэрлэл бөгөөд хавар-зун-намрын улиралд үндсэн үйл ажиллагаа нь явагдаж ургацаа хурааснаар өвөлжилтөнд бэлтгэнэ. Тодруулбал тариалангийн талбайд ажиллах хугацаа ургамал ургалтын хугацаагаар хязгаарлагдаж, хавартаа тарих бэлтгэл, намартаа хураасан ургацаа борлуулах, техник парклах зэрэг өвөлжилтийн бэлтгэл хийнэ. Тиймээс компани бүрэн чадлаараа жилд 210-аас 225 хоног ажиллах бөгөөд бусад хугацаанд оффисын ажилтнууд ажиллана.

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ  
“ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 2 Тариалангийн үйлдвэрлэлийн ажиллах хүчний ажилын горим

№	Ажилчдын ангилал	Ажлын нөхцөл	Хүний тоо	Ажиллах өдөр
1	Компанийн удирдлага	Ердийн	5	1,350.0
2	Механикжуулагчид	Улирлын	11	2,310.0
3	Гүйцэтгэлийн ажилчид	Цаг үеийн	20	1,200.0

## 1.7 Төслийн ашиглалтын технологи

Төсөл хэрэгжүүлэгч нь 7045 га эргэлтийн талбайтай. Жилдээ нийт талбайн 50-60 хувьд буюу 3500-4000 га-д тариалалт хийж үлдсэн талбайд механик болон химийн уринш хийдэг бөгөөд тарилтын өмнөх үе, тарилтын үе, тарилтын дараах үе шат, тарималын технологид тохируулан бордоо болон ургамал хамгааллын бодисыг сонгон хэрэглэхээр төлөвлөсөн байна.

### 1.7.1 Бордоо хэрэглэх технологи

1. Газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж буй бордоог сонгож хэрэглэхдээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, Монгол улсад бүртгэлтэй гарал үүсэл тодорхой, хөрсөнд хурдан задардаг аль болох байгалийн болон биологийн гаралтай түүхий эдээр хийсэн бодисыг сонгон хэрэглэхийг эрмэлзэж байна.
2. Бордоог хэрэглэхдээ хөрсний шинжилгээнд үндэслэж сонгох ба тариалалтын технологи болон ургацын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагаар бордооны захиалгыг ерөнхий агрономич, агрономич тооцоолол гарган санхүүд захиалга өгнө.
3. Шингэн бордоог найруулж, цэнэглэхэд оролцож буй ажилтнууд ХАБЭА зааварчилгааг агрономич болон агротехникч нараас авсны дагуу ажиллах ба хор саармагжуулах хоол хүнс, хөдөлмөр хамгааллын хувцас, нэг бүрийн хэрэгслээр бүрэн хангаж ажилладаг.
4. Шингэн бордоог үрэлгээ хийгдэхээс өмнө үрэндээ зориулалтын машинаар үр ариутгалтай хамт үрэндээ цацаж шингээнэ.
5. Бордож ариутгасан үрийг 24-48 цагийн дотор тариалалтад шилжүүлнэ.



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ  
“ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6. Мөн буудай 3-5 навчтай байхад нь шингэн бордоог 1 га-д 1 л-ээр тооцон 100 л усаар найруулан цацаж хэрэглэнэ.
7. Бутлалтын үед 1 га-д 1 л тооцон 100 л усаар гербицидтэй хольж цацаж хэрэглэнэ.
8. Үрлэн бордоог хэрэглэхдээ үрлэгээ хийх явцтай уялдуулан үртэйгээ зэрэг цацаж хэрэглэнэ. Тун нормыг тохируулахдаа үрийг түлэгдэхгүй үрийн соёололтонд гэмтэл учруулахгүй байхаар тооцож хэрэглэнэ.
9. Үрлэн бордоог буудайн ургалтын явцад тохируулан шууд хөрсөнд цацах байдлаар хэрэглэж болох бөгөөд тун норм хэмжээ, хугацааг тогтоохдоо буудайн ургамлын явцад тулгуурлан ерөнхий агрономич шийдвэрлэнэ.
10. Ургамлын ургалтын үе шатаас хамааран тарималд 1-2 удаагийн давтамжтай цацаж хэрэглэж болно.
11. Ургамал хамгааллын бодисоос гарсан сав баглаа боодол хог хаягдлын заасан цэгт сумын байгаль орчны байцаагч болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллийг байлцуулан шатаах аргаар устгаж байна.
12. Бордоо болон ургамал хамгааллын ажил явагдаж буй үед малчдыг тухайн бүс нутгийн тариалангийн талбайн орчимд мал бэлчээрлүүлэх, ойрхон нүүдэллэх байрлах зэргийг хориглох, зохицуулах шийдвэрийг сумын засаг даргын захирамжаар батлуулан мөрдүүлж ажиллах ба ажил явагдаж буй үед тухайн талбайн орчимд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээг байрлуулж ажилладаг.
13. Хэрэглэсэн бодисын сав баглааг заасан цэгт сумын байгаль орчны байцаагч болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллийг байлцуулан шатаах аргаар устгадаг.

## **БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН,ЭДИЙН- ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

### **2.1 Гадаргын нөхцөл**

Монгол орны физик газарзүйн мужлалаар төслийн болон агуулахын газар нь Хангайн уулархаг их мужийн Сэлэнгэ-Орхоны дундаж өндөр уулсын дэд мужид хамаарна. Сэлэнгэ-Орхоны дундаж өндөр уулсын дэд муж нь Хангайн уулархаг их муждаа хамгийн том газар нутгийг эзлэх бөгөөд аж ахуйн ашиглалтын үүднээс газар ашиглалтанд ихээхэн тохиромжтой, эдийн засгийн өндөр үр ашигтай бүс нутаг тул газар тариалангийн салбарын хөгжүүлэх экологийн нөөц боломжтой нутагт тооцогдоно.

### **2.2 Хөрсөн бүхэвч**

Хөрс газарзүйн мужлалаар Хангайн их мужийн өндрийн бүсшилийн Хөвсгөлийн мужийн Дэлгэрмөрний 46-р тойргийн нутгийг хамаарна. Төсөл хэрэгжих бүс нутгаар уулс хоорондын хотгорын болон уулын хээрийн чулуурхаг ялзмагт хөрс тархсан байна. Үүнд:

Хөндий хотгорын ялзмагт хүрэн хөрс. Энэ хөрс тархсан газраар ихэнх тариалангийн талбай байршиж байгаа бөгөөд талархаг, хөндийрхөг гадаргаар тогтворжсон хөрс ялзмагт үе давхрага дунд зэргийн зузаантай, доод үе давхаргадаа хайрга чулуутай. Үетэн-алаг өвст бүлгэмдэл ноёлно. Нам уул, ухаа толгодын хүрэн хөрс. Энэ хөрс Тариалан сумын төв хэсгийг хамран хойшоо голдуу тархсан бөгөөд ялзмагт үеийн зузаан хөндийн хөрснөөс бага зэрэг нимгэрнэ. Ургамлан нөмрөгт жижиг дэгнүүлт үет ургамлын оролцоо ихсэнэ.


### **2.3 Уур амьсгал**

Уур амьсгалын тоон ангилалаар Тариалан сум нь Хөвсгөлийн өндөр уулын тайга, Хөвсгөлийн ойт хээр, Хангайн нурууны арын Идэр, Эгийн голын орчмын ойт хээрийн хэсгийн мужид, Булган аймаг нь Ханжаргалан уулсын ойт хээрийн хэсгийн мужид багтана. Хуурайвтар сэрүүн зунтай, өвөлдөө хур тунадас их унадаг, цасан бүрхүүд ихтэй, хүйтэн. 1 дүгээр сарын дундаж температур дунджаар -35°C-ийн хэм, 7 дугаар

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

сарын дундаж температур +18-аас +20°C-ийн хэмтэй ба жилийн дундаж салхины хурд 1.5-аас 1.7 м/с, жилийн хур тунадасны нийлбэр 300 орчим мм байдаг. Хөвсгөл болон Булган аймаг нь уур амьсгалын үзүүлэлтээр ижил нөхцөлтэй болохыг харуулна. Төслийн талбай нь уур амьсгалын нөөцийн мужлалаар агаарын жилийн дундаж дулаан -1-ээс -3 хэмийн, тунадасны хэмжээгээр жилд дунджаар 225-284 мм тунадас унадаг мужлалд хамаарна. Энэ нь ургамалд ашигтай дулаан болон чийгээр хамгийн дутмаг бүс буюу чийглэгдүү-сэрүүвтэр бүсэд байршиж байгаа гэсэн үг юм. Энэ нь хуурайшлын индексээр тус бүс нутгийг ландшафтын чадавхийн хувьд дунд зэргийн үнэлэмжтэй байна.

## 2.4 Агаарын чанар



Зураг №. 4 Уур амьсгалын нөөцийн олон жилийн дундаж үзүүлэлт

Төсөл хэрэгжих өөр байршилтай төслийн объектууд нь агаарын чанрын харилцан адилгүй бүсэд байна.

## 2.5 Хөвсгөл аймгийн агаарын чанарын үзүүлэлт

Хөвсгөл аймгийн хэмжээнд агаарын бохирдолын томоохон голомт нь Мөрөн хот бөгөөд агаарт хамгийн их бохирдол үүсдэг, галлагааны улирлын байдлаар 3 дугаар сарын I дүгээр 10 хоногийн азотын давхар ислийн дундаж агууламж 0.017 мг/м<sup>3</sup> хамгийн их нь 0.030 мг/м<sup>3</sup>, хүхэрлэг хийн дундаж агууламж 0.010 мг/м<sup>3</sup> хамгийн их нь 0.027 мг/м<sup>3</sup>, нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламжийн дундаж 1.48 мг/м<sup>3</sup>, хамгийн их нь 3.14 мг/м<sup>3</sup>, PM10 тоосонцорын оногийн дундаж 0.103 мг/м<sup>3</sup>, хамгийн их нь 0.164 мг/м<sup>3</sup> байсан байна.


ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 4 дүгээр сарын II дугаар 10 хоногийн азотын давхар ислийн дундаж агууламж 0.015 мг/м<sup>3</sup> хамгийн их нь 0.024 мг/м<sup>3</sup>, хүхэрлэг хийн дундаж агууламж 0.008 мг/м<sup>3</sup> хамгийн их нь 0.035 мг/м<sup>3</sup>, нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламжийн дундаж 1.88 мг/м<sup>3</sup>, хамгийн их нь 3.64 мг/м<sup>3</sup>, PM10 тоосонцорын оногийн дундаж 0.034 мг/м<sup>3</sup>, хамгийн их нь 0.064 мг/м<sup>3</sup> хүрч PM<sub>10</sub> тоосонцрын агууламж нь агаарын чанарын стандартыг 3 удаа давсан бохирдолтой байна.

### Булган аймаг

Булган суманд агаар дахь хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 0.006 мг/м<sup>3</sup>, хамгийн их агууламж 0.009мг/м<sup>3</sup>, агаарын чанарын MNS 4585:2016 стандарттай харьцуулахад хэвийн хэмжээнд, азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 0.017 мг/м<sup>3</sup>, хамгийн их агууламж 0.026 мг/м<sup>3</sup> хүрсэн нь агаарын чанарын стандартын төвшинд байна.

■ Булган (Булган – Булган хот, Аймгийн УЦУОША–д)



■ Булган (Булган – Булган хот, Аймгийн УЦУОША–д)




График №. 1 агаарын үзүүлэлт


ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 2.6 Гадаргын ус

Тариалан сумын төв нь Сэлэнгэ мөрний эргээс хойшоо орших ба хамгийн ойр хэсгээрээ бригадын төвөөс 23.7 км, хамгийн ойр байрших тариалангийн талбайгаас 1.8 км зайд байрших ба гадаргын усны үерийн аюулд өртөх магадлал багатай нахцалд байршиж байгаа юм. Тариалангийн талбай дундуур урсах Зүлэгтийн гол нь Алтандуулга, Их луулын завсраар урсан Сэлэнгэ мөрөнд цутгах боловч байнгын урсгалтай биш, ихэнхдээ хуурай сайр байна.

## 2.7 Газрын доорхи ус

Хөвсгөл аймгийн гадаргын уснаас Сэлэнгэ мөрөн хамгийн том нь бөгөөд сумын ус хангамжинд шууд утгаараа бус ч газрын доорх усны тэжээл болохын хувьд хамгийн чухалд тооцогддог. Тариалан сумын хувьд газрын доорхи усны нөхөн сэргээгдэх нөөц нь нэгж км<sup>2</sup>-д жилд 5 мм-ээс бага байгаа тэжээгдлийн мужид төслийн талбай байршиж байна. тиймээс төслийн бүс нутагт хэрэгдээний усны хэмжээг аль болох гадаргын нөөцөөс хангаж байх хэрэгтэй байна. Харин Булган аймгийн хувьд газрын



Зураг №. 5 Газрын доорхи усны нөхөн сэргээгдэх нөөц

доорхи усны тэжээгдлийн хэмжээ Тариалан сумынхтай ижил байх авч Булган хотын орчинд газрын доорхи усны Майдарын гол ордтой байна

## **2.8 Ан амьтан**

Төсөл хэрэгжих бүс нутгаар том амьтдын гүйдэл бараг байхгүй, зурам жижиг мэрэгчид байх бөгөөд нягтшил нь мөн тийм их биш юм. Гол төлөөлөгчид нь Монгол чичүүл, алагдаахай байх ба уулсын ар бэлээр зурам, алагдаахай зэргээс гадна үнэг, хярсны гүйдэл байх ч жилээс жилд багассаар байна. Тариалангийн талбайд захаар талын оготно /Lagurus/, азийн хулганы нүх ажиглагдсан ба үүнийг дагаж тарлан сар /Buteo lagopus/ харагдаж байлаа. Эдгээрээс гадна хээрийн болжмор, хөхвөр тагтаа, хэрээ, элээ, шаазгай зэрэг байнгын суурьшилтай шувууд элбэгшиж, ялангуяа тариа хураалтын үед тариалангийн талбай үтрэм, будааны агуулахын орчинд тоо толгой нь эрс элбэгшинэ. Эдгээрээс МУ-ын амьтны аймгийн тухай хуулийн нэн ховор амьтан гэсэн жагсаалтанд орсон зүйл үгүй бөгөөд, 2001 оны Засгийн газрын 164-р тогтоолоор баталсан ховор амьтны жагсаалтанд орсон 6 зүйл байгаа юм.

## **2.9 Ургамалан бүрхэвч**

Төслийн үйлдвэрийн бүс нутаг нь ургамалжилтын тойргоор Хангайн тойрогт хамаарна. Төсөл хэрэгжих талбайд бригадын талбайн барилга байгууламжийг барьсан бөгөөд тус газар нь байршлаасаа шалтгаалан газар, хөрсний талхлагдалд өртсөний учир газар ашиглалттай холбоотой ургамлан нөмрөг талхлагдсан байна.

Тариалангийн талбай: Нэг төрлийн таримал дагнан тарьж байгаагаас шалтгаалан тариалангийн талбайд чөдөр тарна, татар сагаг, хонгио хошуу будаа, ногоон будаа, бог будаа, тарианы хар будуу, хөдөөгийн шаралзгана, арзгар азаргана, мөлхөө хиаг, хүрэн ягаан ноной зэрэг төрөлжсөн хог ургамлын тархалтууд тарималтай цуг зэрэгцэн ургац байна. Зарим ургамал тариалангийн талбайд байнга байрших замаар тарималд төрөлжинө гэдэг нь дараах шалтгаантай байдаг байна. Үүнд:

Ихэнхи төрөлжсөн ургамлын хавар соёолох, намар хагдрах хугацаа нь төрөлжсөн таримл ургамлынхаа тариалалт, хураалтын хугацаатай давхцсан байдаг

Нэг болон цөөн наст, үрээр үрждэг ургамлын хэмжээ нь үр тарианы үрийн хэмжээтэй адил байх тул комбайны бункер-үтрэм-агуулах-үрлэгч гэсэн замаар тархалтын хүрээгээ тэлж нэг талбайгаас нөгөө талбайд нүүдэллэн ургадаг. Үндсээрээ, үндэслэг ишээр, үндэсний найлзуураар үрждэг ургамлууд хөрс боловсруулалтын технологиор үржих идэвх нь сэргэж эрчимжэж байдаг.

### **2.10 Усан хангамж**

“Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн оффис болон аж ахуйн хашаа бүхий газар дахь барилга, байгууламжууд Тариалан сумын цэвэр усан шугам сүлжээтэй холбогдсон тул унд ахуйн хэрэглээний ус болон цэвэр усаа сумын нэгдсэн шугамаас хангадаг байна.

### **2.11 Эдийн засаг**

Газар тариалан нь тус сумын эдийн засгийн үндсэн салбар тул хүн амын ихэнх нь сумын төвдөө амьдарна. Жилд дунджаар 10000 га -д үр тариа тариалдаг. 2017 оны байдлаар 229122 толгой мал тоологдсоны 92295 нь ямаа, 101916 нь хонь, 22921 нь үхэр, сарлаг, 11990 нь адуу, 0 нь тэмээ байв. 11739 га-д үр тариа тариалж 19716 тн ургац хураан авсан. Хувийн хэвшлийн 80 гаруй аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэл үйлчилгээ явуулж жилдээ 17,0 тэр бум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Хөвсгөл аймгийн гурилын хэрэгцээг бүрэн хангах хүчин чадалтай гурилын үйлдвэрүүд ажиллаж байна.

### **2.12 Лаборатори**

Түүхий эд, бүтээгдэхүүний шинжилгээг Монгол улсад мөрдөгдөж буй холбогдох стандартын дагуу хийх тоног төхөөрөмжөөр тоноглогдсон гурилын үйлдвэрийн лаборатори нь 30м<sup>2</sup>, үр тариа хүлээн авах хэсгийн лаборатори нь 16м<sup>2</sup> талбайтай. Лабораторийн эрхлэгч-1, мэргэжлийн шинжээч 4 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг

### **2.13 Авто зам**

Хөвсгөл аймгийн нутгаар улсын болон орон нутгийн чанартай 5547 км авто зам дамжин өнгөрч байгаагаас улсын чанартай зам 1065 км, орон нутгийн чанартай зам 1848 км, сумаас баг хүртлэх 2834 км ердийн хөрсөн зам байна. Аймгийн төвөөс

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ  
“ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улаанбаатар чиглэлд 160 км-т Тариалан сум оршиж, тус сум улсын чанартай хатуу хучилттай замаар аймгийн төв болон, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудтай холбогдоно. Улсын чанартай автозамаас Тариалан сумын төв хүртэл 8 км шороон замаар явахаас гадна Тариалан сумын төвд байх “Хөвсгөл Алтан дуулга” ХК-ий оффисын талбайгаас тариалангийн талбай хооронд орон нутгийн хөрсөн замаар явна. Харин эрдэс бордоог БОАЖСайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 28/40/29 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 3.3-т заасны дагуу ОХУ-аас импортлох бордоог дараах маршрутын дагуу тээвэрлэнэ.



### **БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ ӨӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

#### **3.1 Газар болон хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Бүтээн байгуулалтын хувьд төсөл хэрэгжүүлэгч нь шинээр хийх бүтээн байгуулалт байхгүй, газрын хэвлийд нэвтрэх үйл ажиллагаа байхгүй ба нөлөөлөлд тогтворжсон. Үйлчилгээний үйл ажиллагааны хувьд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэх бохир хаягдлыг гэрээний үндсэн дээр зайлуулна, ахуйн бохирдол үүсэх нөхцөл байнгын давтамжтай ба үнэлэх шаардлагатай.

#### **3.2 Агаар, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Үйл ажиллагааны хувьд тариалангийн гол ажиллагаа дулааны улиралд явагдах ба нөлөөллийн давтамж буурна. Хог хаягдалын хувьд дахин боловсруулах боломжгүй хит бохирдолтой ахуйн хогийг сумын ЗДТГ-тай хийсэн гэрээгээр зайлуулна. Эрдэс бордооны хэрэглээнээс үүсэх хог хаягдал аюулгүй ХАА-н техник хэрэгслийн засвар үйлчилээнээс гарах хаягдал аюултай байж болзошгүй ба үнэлэх шаардлагатай.

#### **3.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Үйлчилгээний үйл ажиллагааны хувьд Үйл ажиллагаанаас гарсан хаягдал гадаргын ус, урсац болон гүний ус хүртэл нэвчих бохирдол үүсэх магадлал багатай. Эрдэс бордоо хэрэглэхэд ус бохирдох магадлал бага ба үнэлэх шаардлагатай. Усны хэрэглээний хувьд Төсөл үйл ажиллагаандаа нийт 604.8 тн/жид ус хэрэглэх ба энэ нь зөвхөн унд ахуйн хэрэгцээнд зориулагдана. Төслийн технологийн усны хэрэглээг сумын төвлөрсөн ус хангамжийн гүний худгаас хангах ба үнэлэх шаардлагатай.

#### **3.4 Хөрс, ургамал, амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл**

Газар ашиглалтын хувьд Тариалангийн талбайнууд нь эрчимтэй ашиглалттай, жил бүр элдэншүүлэгтэй Бригад орчимд хөрс, газрыг бохирдуулах, ургамлан нөмрөгийг тахлах давтамж ургамал ургах хугацаатай давхцалтай ба үнэлэх шаардлагатай. Үйл ажиллагааний хувьд Хөрс, ургамлын тахлагдах төслийн талбайн хил хязгаараас давах боломжтой ба энэ нь талбай хоорондын зайнаас хамааралтай. Зүйлийн олон янз байдал үзүүлэх сөрөг нөлөө урьдчилсан байдлаар тодорхойлогдоогүй ба үнэлэх шаардлагатай.

#### **БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙНТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр тусгасан байдаг. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж, дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байхаар тус тус зохицуулсан билээ. Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх шаардлага мөн тавигдсан байдаг.

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Зардал (сая.төг)
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	800,0
1.1		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	700,0
1.2		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	250,0
1.3		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ  
“ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 1 жилийн зардал	2 511 00
--------------------------	----------

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь “Хөвсгөл Алтан Дуулга” ХК-ийн “Эрдэс бордоо импортлох, түр хадгалах, хэрэглэх, борлуулах” төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино Ингэхдээ, төсөл хэрэгжүүлэгч тухайн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлж болохуйц, бодиттой арга хэмжээг төлөвлөн тусгахыг эрхэм болголоо. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2023 оны 1 жилийн хугацаанд менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **2 511 000** төг зарцуулахаар төсөвлөгдсөн байна.

**БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (мян.төг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт
1	Агаар	Төслийн хэрэгцээнд ашиглаж буй автомашины яндангаас үүсэх утаа, хорт хийг багасгах зорилгоор тэдгээрийн техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, эвдрэл гэмтлийг даруй засаж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны талбайн машин явах зам болон замтай ойролцоох газар	-	-	-	-	Жил бүр	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS(ISO)13688 :2000 MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004
		Химийн бодисын алдагдлыг илрүүлэгч автомат төхөөрөмж, галын аюулгүй байдлыг хангах дохиоллын систем суурилуулах	Агуулах орчинд	-	200,0	-	200,0	Жил бүр	MNS 0012-013:1991. Ажлын байрны агаар. Ажлын байрны агаарын бүс MNS4585:2016 Агаарын чанар. Техникийн

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		бодис ангилан хадгалах тавиур, хийж шаардлага хангахуйц бэхлэн тогтоох	Агуулах орчинд	-	-	-	-	2023 он	ерөнхий шаардлага. MNS5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага Агаарын тухай хууль 21.1, 29.1 Байгаль орчныг хамгаалах тухай хууль 21.3
		Орчны болон ажлын байрны агаарын бохирдлын байдалд шинжилгээ хийлгэх (жилд 1 удаа 2 байршил дээр)	Агуулах орчинд	-	-	-	-	Орчны хяналт шинжилгээ мониторингийн хэсэг дээр оруулсан	
		Галын хор, гал унтраах хэрэгсэлээр хангах	Агуулах орчинд	-	250,0	-	500,0	2023он	
		Талбайд хэрэглэсэн химийн бодисын тун хэмжээ, хугацаа зэрэг мэдээллийг талбайн дэвтэрт тогтмол тэмдэглэх, бүртгэл хөтлөх	Агуулах орчинд	-	-	-	-	2023 он	
2		Ажилчдыг химийн бодистой ажиллахад нэг удаагийн хамгаалах	Үйл ажиллагааны үед	-	-	-	Үйл ажиллагааны зардалд	Жил бүр	

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

		хэрэгсэлээр бүрэн хангах, холбогдох бүртгэлийг хөтлөх						
3	Хөрс болон ургамлан бүрхэвч	Төслийн үйл ажиллагааны үед тос, тослох материалыг ил задгай хаяхгүй байх сургалт явуулах	Төслийн талбай	-	-	-	-	Жил бүр
4		Хөрсөн бүрхэвчийн чанарын өөрчлөлт, элэгдэл эвдрэлийг тогтмол хянах	Тариалнгийн талбай бүхэлдээ	-	-	-	-	Жил бүр
5		Шаардлагагүй газар ухаж сэндийчихгүй байх	Үйл ажиллагааны явцад	-	-	-	-	Жил бүр
Нийт 700 000								

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян,төг	Хэрэгжүүлэх хугцаа ба давтамж	Баримтлах эрх зүй баримт бичиг
1	Төслийн талбайд ногоон байгууламжтай болсоноор агаарын тоосжилт буурах юм.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн талбай болон үйлдвэрийн орчинд мод тарих	Төслийн талбай	-	-	-	3750,0	Үйл ажиллагааны явцад	MNS 3985:1987 Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл
		Агуулахын хажууд цэцэг зүлэг тарих	Агуулахын орчинд	-	-	-	-	Үйл ажиллагааны явцад	
		Агуулахын гадаа болон дотор хогийн савтай байх	Агуулахын орчинд	-	-	-	-	Үйл ажиллагааны явцад	
2		Тариалан сумын Бумбат толгойн цогцолбор-цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, бүтээн байгуулалт		-	-	-			
Нийт 375,0									

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугцаа ба давтамж	Баримтлах эрх зүйн бримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Хөвсгөл аймаг Тариалан сум “Зүлэгтийн голын бичээс”	Соёлын өвийг хамгаалах хуулыг дагах	Сумын хүрээнд	-	-	-	Жил бүр	Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах хуулыг даган мөрдөх
2	Хөвсгөл аймаг Тариалан сум “Зүлэгтийн голын буган чулуун хөшөө”	Соёлын өвийг хамгаалах хуулыг дагах	Сумын хүрээнд	-	-	-	Жил бүр	
3	Булган аймгийн Булган сум “Диваажингийн сүм”	Соёлын өвийг хамгаалах хуулыг дагах	Сумын хүрээнд	-	-	-	Жил бүр	
4	Булган аймгийн Булган сум “Майдарын голын цагаан суварга”	Соёлын өвийг хамгаалах хуулыг дагах	Сумын хүрээнд	-	-	-	Жил бүр	
Нийт								



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах жрх зүйн баримт бичиг
1	Байгалийн давагдашгүй хүчин зүйл болж гал гарч химийн бодис галд өртөж шатвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Байгаль хамгаалал, болзошгүй гал түймэрээс урьдчилан сэргийлэх талаар ухуулга, сурталчилгааны самбар хийж байрлуулан, тухай бүрд нь шинэчилж байх	Төслийн талбай болон агуулах	-	100,0	100,0	Жил бүр	MNS5566:2005. Аж ахуйн нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага
2		Галын багаж хэрэгсэл авч ашиглахад бэлэн байдлаар байрлуулах (амьсгалын нэг бүрийн хмагаалалтын аппарат, галын хор, гал унтраагч, усан шүршүүр, гал унтраах хуурай хэрэгсэл, хөөс, нүүрсхүчлийн хий гэх мэт)	Төслийн талбай болон агуулах	-	200,0	200,0	Жил бүр	
3		Бодис урвалжуудын хор аюулын зэргийг харуулсан тэмдэг, тэмдэглэгээг монгол тайлбараар дэлгэрэнгүй хийх	Төслийн талбай болон агуулах	-	-	-	2023 он	MNS5029:2011. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг.
	Химийн бодис их хэмжээгээр асгарвал	Химийн бодисыг ангилан ялган тус тусд нь тавих	Агуулахын хүрээнд	-	-	-	2023 он	MNS6458:2014. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй,

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	аюултай нөхцөл байдал үүснэ.							Химийн хорт болон аюултай бодис”	
		Болзошгүй тохиолдлоор химийн бодис асгарсан тохиолдолд хэрэглэх зориулалтын шингээгч, хүнсний сод, хуурай элс, шороо, тогтворжуулагч, үртэс гэх мэт материалуудыг ажлын талбарт бэлэн байлгах	Агуулахын хүрээнд	-	200,0	200,0	2023 он	Тухайн бодисын хор аюулгүйн лавлах мэдээлэл (MSDS)	
		Ажиллагсдыг осол аваар, галын аюулаас хамгаалах арга хэмжээнд сургах ажлыг зохион байгуулалттайгаар явуулах	Агуулахын хүрээнд	-	50,0	200,0	Жил бүр		
					Нийт 700,0				

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БҮЛЭГ 9. ХОГ, ХЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хог хаягдал ангилах	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Айхуйн	Хаягдлыг ил задгай хаяхгүй байх сургалт зохион байгуулах	Тариалангийн талбай болон агуулах	-	Сумын ТҮК-д нийлүүлэх	-	-	Үйл ажиллагааны хугцаанд	Хог хаягдлын тухай хууль
		Ангилан ялгаж тус тусад нь хийх савтай болгох	Тариалангийн талбай болон агуулах	-	50,0	-	250,0	Үйл ажиллагааны хугцаан	
2	Аюултай	Органик химийн хаягдлыг аюултай хог хаягдал устагдаг газартай гэрээ байгуулан ажиллах.	Агуулах хэсэгт	-	-	-	Аюултай хог хаягдлын компаниитай гэрээ байгуулах	Үйл ажиллагааны хугцаанд	
Нийт 250 000									

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийит зардал, төг	тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Хөрс								
1	Хөрсний механик бүрэлдэхүүн	Төслийн талбайн нэг цэг сонгон хөрсний шинжилгээ хийлгэх.	2023 он	Жилд 1 удаа	70,0	140,0	Хөрсийг агрохими, хүнд мяталл, эрүүл ахуй, механик бүрэлдэхүүний шинжилгээг хийлгэнэ	химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга,
2	Хөрсний агрохимин үзүүлэлт							
3	Хөрсний хүнд металлын үзүүлэлт							
	Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт							
Агаар								
4	Агаар	Төслийн талбайн нэг цэг сонгон шинжилгээ хийлгэх.	2023 он	Жилд 1 удаа	100,0	200,0	Агаарын тоосны (TSP, PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub> ) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх Агаарын бохирдлын (NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO, Тоос, H <sub>2</sub> S <sub>3</sub> , NH <sub>3</sub> ) шинжилгээ хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар хийнэ	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколоримтерийн арга MNS 5013:2009 Дизель хөдөлгүүртэй
5	Дуу шуугиан		2023 он	Жилд 1 удаа				

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН СУМ, БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖИХ “ЭРДЭС БОРДОО ИМПОРТЛОХ, ТҮР ХАДГАЛАХ, ХЭРЭГЛЭХ, БОРЛУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

									автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
Усны шинжилгээ									
6	Усны ерөнхий үзүүлнлт	Усны эх үүсвэрээр	2023	Жилд 1 удаа	46.0	46.0	Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO <sub>3</sub> ), Ca, Mg, Na, K, SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , NH <sub>4</sub> , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)	<b>Усны хяналт шинжилгээ:</b> Усны чанар: рН, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO <sub>3</sub> ), Ca, Mg, Na, K, SO <sub>4</sub> , NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , NH <sub>4</sub> , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)	
Нийт 386 000									

**БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Харилцсан албан тушаалтан	Тайлбар
			2023он				
			Сар 5	Сар 3	Сар9		
1	Ажилчдад байгаль орчныг хамгаалах талаар сургалт зохион байгуулах	-	+	-	+	Байгаль орчны мэргэжилтэн	
2	Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн журам гарган ажилчдад мөрдүүлэн ажиллах.	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	ХАБ –ийн мэргэжилтэн болон жхүүл ахуйч	
3	Гал түймрээс урьдчилан сэргийлэх багаж хэрэгсэл байрлуулах.	-	+	+	+	Захирал	
	Осол эрсдэлийн төлөвлөгөө боловсруулах.	-	+	+	+	Захирал	
			Нийт				

**БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Булган аймаг Булган сумынболон Хөвсгөл аймгийн Тариалан сумын засаг захиргааны байгууллагад танилцуулж,хэлэлцүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж бичвэр хэлбэрээр сумдын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	БОМТ-ний хэрэгжилтийн явцад орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон оршин суугчдад танилцуулна.	-	Байгал орчны мэргэжилтэн болон захирал сумын засаг захиргааны ажилчид	Хөвсгөл аймгын Тариалан сумын болон Булган аймгийн Булган сумын Засаг захиргааны байранд
2	БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Хөвсгөл аймгын Тариалан сумын болон Булган аймгийн Булган сумын нутгийн оршин суугчдад танилцуулж хэлэлцүүлнэ.	Нутгийн оршин суугчдад БОМТ-ний биелэлтийг тайлагнах уулзалт зохион байгуулах	БОМТ-ний биелэлт		-	Байгал орчны мэргэжилтэн болон захирал сумын засаг захиргааны ажилчид, нутгийн ард иргэд	
Нийт 100,0							